



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/586

Эрдэнэт

┌ Дэмжлэг үзүүлэх тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.2, 10.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл мэнд нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 75 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан Дархан, Улаанбаатар хотноо зохион байгуулагдах урлаг, спортын наадамд Орхон аймгаас оролцох баг бүрэлдэхүүнд 1500000 төгрөгийн, “Эрдэнэтийн цом” сагсан бөмбөгийн улсын чанартай тэмцээнийг зохион байгуулахад 500000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 2000000 /Хоёр сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ